НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/348/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: Я.Алтанцэцэг<br>Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр<br>Утас: 325093 Цахим хаяг: munkhdelgerd@audit.gov.mn<br>Аудитор: Д.Эрдэнэбулган<br>Утас: 325093 Цахим хаяг: erdenebulgand@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 66

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ЦОГБАДРАХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 12.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 46.6 сая төгрөг нийт 59.3 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/802 дугаар захирамж, хэлтсийн даргын А/21 дүгээр тушаалаар 41.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

1426050113

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/*төгрөгөөр*/

| Дансны томьёо | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6 | 521,331,039.71 | 676,636,367.59 |
| 351 | Түүхий эд материал | | 451,923,437.41 | 608,878,078.69 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | | 451,472,471.97 | 608,427,113.25 |
| 3513 | Эм боох материал | | 450,965.44 | 450,965.44 |
| 354 | Хангамжийн материал | | 68,607,602.30 | 66,958,288.90 |
| 3541 | Бичиг хэргийн материал | | 3,512,690.00 | 3,868,000.00 |
| 3542 | Аж ахуйн материал | | 1,629,804.00 | 2,208,904.00 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | | 45,044,521.00 | 34,690,678.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | | 3,410,757.30 | 2,747,126.90 |
| 3545 | Барилгын засварын материал | | 107,000.00 | 5,107,000.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | | 14,902,830.00 | 18,336,580.00 |
| 356 | Мал амьтад | | 800,000.00 | 800,000.00 |
| 3-37-39 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 521,331,039.71 | 676,636,367.59 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 2,745,816,284.88 | 2,459,299,524.05 |
| 392 | Биет хөрөнгө | | 2,618,672,251.66 | 2,332,176,324.05 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,881,204,812.67 | 1,881,204,812.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | -384,414,831.27 | -460,735,360.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 1,778,905,556.44 | 1,819,905,556.44 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | -743,008,163.19 | -963,787,107.62 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 129,829,387.28 | 129,829,387.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | -58,302,158.63 | -88,913,511.71 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 18,757,750.00 | 24,807,750.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | -6,045,168.60 | -11,225,869.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 6,544,000.00 | 6,544,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | -4,798,933.04 | -5,453,333.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | | 127,144,033.22 | 127,123,200.00 |
| 39301 | Программ хангамж | | 375,000.00 | 375,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | -354,166.78 | -375,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 127,123,200.00 | 127,123,200.00 |
| 37+39 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,745,816,284.88 | 2,459,299,524.05 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 3,267,147,324.59 | 3,135,935,891.64 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 3,267,147,324.59 | 3,135,935,891.64 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 176,352,922.87 | 176,352,922.87 |
| 51101 | Өмч: - төрийн | | 176,352,922.87 | 176,352,922.87 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | | 3,031,471,260.53 | 2,900,259,827.58 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | | 2,990,836,223.54 | 3,031,471,260.53 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 40,635,036.99 | -131,211,432.95 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 59,323,141.19 | 59,323,141.19 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 3,267,147,324.59 | 3,135,935,891.64 |
| 4+5 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 3,267,147,324.59 | 3,135,935,891.64 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 1,450,606,700.00 | 1,743,800,380.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | 1,378,879,700.00 | 1,684,515,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,378,879,700.00 | 1,684,515,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 71,727,000.00 | 59,284,980.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 29,400,000.00 | 12,707,480.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 42,327,000.00 | 46,577,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 524,716,434.36 | 321,635,566.78 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 524,716,434.36 | 321,635,566.78 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 323,221,979.01 | 42,300,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 201,494,455.35 | 279,335,566.78 |
| 12+13 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2 | 1,975,323,134.36 | 2,065,435,946.78 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,934,688,097.37 | 2,196,647,379.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,925,263,977.83 | 2,175,042,602.04 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,145,536,076.12 | 1,390,299,246.22 |
| 210101 | Үндсэн цалин | | 596,830,176.12 | 790,466,046.22 |
| 210102 | Нэмэгдэл | | 538,507,900.00 | 519,455,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 9,817,000.00 | 28,071,400.00 |
| 210104 | Урамшуулал | | 381,000.00 | 52,305,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 24,476,700.00 | 30,881,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 1,271,800.00 | 1,346,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 149,600.00 | 158,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 74,800.00 | 81,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 74,800.00 | 1,471,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 22,905,700.00 | 27,824,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 72,746,915.34 | 78,891,540.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 7,151,506.34 | 11,391,514.09 |
| 210302 | Түлш, халаалт | | 60,192,000.00 | 60,192,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,403,409.00 | 7,308,026.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 50,756,918.50 | 51,528,400.40 |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,283,390.00 | 4,526,390.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | | 43,891,178.50 | 41,959,910.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,014,600.00 | 1,140,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 507,600.00 | 507,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,060,150.00 | 3,393,900.00 |
| 2105 | Нормативт зардал | | 98,881,843.12 | 120,302,667.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 1,126,000.00 | 5,985,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 42,577,000.00 | 45,169,630.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 55,178,843.12 | 69,148,037.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 38,760,000.00 | 45,685,150.00 |
| 210604 | Урсгал засвар | | 38,760,000.00 | 45,685,150.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 44,024,359.00 | 56,417,446.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 40,047,000.00 | 51,146,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 790,221.00 | 2,884,630.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 220,000.00 | 220,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,205,000.00 | 1,023,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 1,762,138.00 | 1,143,316.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 450,081,165.75 | 401,037,052.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 57,210,751.03 | 67,470,291.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 387,170,414.72 | 333,566,760.83 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 9,424,119.54 | 21,604,777.69 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 5,655,000.00 | 8,586,400.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 0 | 2,116,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 5,655,000.00 | 6,470,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 3,769,119.54 | 13,018,377.69 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,769,119.54 | 13,018,377.69 |
| 2-225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3 | 1,934,688,097.37 | 2,196,647,379.73 |
| 11+12+13-21-22+225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | | 40,635,036.99 | -131,211,432.95 |
| 12+13+14-21-22-23-24-25 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | | 40,635,036.99 | -131,211,432.95 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 12+13 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,450,606,700.00 | 1,743,800,380.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,450,606,700.00 | 1,743,800,380.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,378,879,700.00 | 1,684,515,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,378,879,700.00 | 1,684,515,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 71,727,000.00 | 59,284,980.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,400,000.00 | 12,707,480.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,327,000.00 | 46,577,500.00 |
| 21 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,438,943,700.00 | 1,739,050,380.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,438,943,700.00 | 1,739,050,380.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,429,519,580.46 | 1,717,445,602.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,145,536,076.12 | 1,390,299,246.22 |
| 210101 | Үндсэн цалин | 596,830,176.12 | 790,466,046.22 |
| 210102 | Нэмэгдэл | 538,507,900.00 | 519,455,900.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,817,000.00 | 28,071,400.00 |
| 210104 | Урамшуулал | 381,000.00 | 52,305,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,476,700.00 | 30,881,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,271,800.00 | 1,346,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 149,600.00 | 158,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 74,800.00 | 81,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 74,800.00 | 1,471,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,905,700.00 | 27,824,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 72,746,915.34 | 78,891,540.09 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,151,506.34 | 11,391,514.09 |
| 210302 | Түлш, халаалт | 60,192,000.00 | 60,192,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,403,409.00 | 7,308,026.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 44,479,130.00 | 46,149,020.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,588,930.00 | 3,764,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,500,000.00 | 36,763,280.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,014,600.00 | 1,140,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 507,600.00 | 507,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,868,000.00 | 3,973,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 41,712,000.00 | 42,869,630.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,712,000.00 | 42,869,630.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 36,625,000.00 | 52,612,020.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 36,625,000.00 | 49,612,020.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,776,759.00 | 58,097,446.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,799,400.00 | 52,226,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 790,221.00 | 2,884,630.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 220,000.00 | 220,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,205,000.00 | 1,623,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,762,138.00 | 1,143,316.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,167,000.00 | 17,645,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,467,000.00 | 17,645,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 9,424,119.54 | 21,604,777.69 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,655,000.00 | 8,586,400.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 0 | 2,116,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,655,000.00 | 6,470,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,769,119.54 | 13,018,377.69 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,769,119.54 | 13,018,377.69 |

| | | | |
|---|---|---|---|
| 12+13-21 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 11,663,000.00 | 4,750,000.00 |
| 22 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 11,663,000.00 | 4,750,000.00 |
| 22-226 | Дотоод эх үүсвэрээр | 11,663,000.00 | 4,750,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,663,000.00 | 4,750,000.00 |
| 140-22 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -11,663,000.00 | -4,750,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

***/төгрөгөөр/***

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцоо дүн |
|---|---|---|---|---|
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 176,352,922.87 | 59,323,141.19 | 2,990,836,223.54 | 3,226,512,287.60 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 40,635,036.99 | 40,635,036.99 |
| . . . . . . . . . . . . . . . . | 0 | 0 | 0 | 0 |
| . . . . . . . . . . . . . . . . | 0 | 0 | 0 | 0 |
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 176,352,922.87 | 59,323,141.19 | 3,031,471,260.53 | 3,267,147,324.59 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0 | 0 | 0 | 0 |
| Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -131,211,432.95 | -131,211,432.95 |
| . . . . . . . . . . . . . . . . | 0 | 0 | 0 | 0 |
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 176,352,922.87 | 59,323,141.19 | 2,900,259,827.58 | 3,135,935,891.64 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Дансны код | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 13 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 0 | 1,671,497,022.31 | -1,671,497,022.31 | - |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0 | 1,671,497,022.31 | -1,671,497,022.31 | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 0 | 1,684,515,400.00 | -1,684,515,400.00 | - |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 0 | 1,671,497,022.31 | -1,671,497,022.31 | - |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,684,515,400.00 | 1,671,497,022.31 | 13,018,377.69 | 99.23 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,676,528,900.00 | 1,663,510,622.31 | 13,018,277.69 | 99.22 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,390,788,200.00 | 1,390,299,246.22 | 488,953.78 | 99.96 |
| 210101 | Үндсэн цалин | 790,954,900.00 | 790,466,046.22 | 488,853.78 | 99.94 |
| 210102 | Нэмэгдэл | 519,455,900.00 | 519,455,900.00 | 0.00 | 100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 28,071,400.00 | 28,071,400.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 52,306,000.00 | 52,305,900.00 | 100.00 | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,881,100.00 | 30,881,100.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,346,400.00 | 1,346,400.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 158,300.00 | 158,300.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 81,100.00 | 81,100.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,471,000.00 | 1,471,000.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,824,300.00 | 27,824,300.00 | 0.00 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 81,613,900.00 | 78,891,540.09 | 2,722,359.91 | 96.66 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,867,100.00 | 11,391,514.09 | 2,475,585.91 | 82.15 |
| 210302 | Түлш, халаалт | 60,192,000.00 | 60,192,000.00 | 0.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,554,800.00 | 7,308,026.00 | 246,774.00 | 96.73 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 46,403,700.00 | 44,462,140.00 | 1,941,560.00 | 95.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,844,000.00 | 3,764,540.00 | 1,079,460.00 | 77.72 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,076,400.00 | 35,076,400.00 | -2,000,000.00 | 106.05 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,012,500.00 | 1,140,600.00 | 2,871,900.00 | 28.43 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 506,000.00 | 507,600.00 | -1,600.00 | 100.32 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,964,800.00 | 3,973,000.00 | -8,200.00 | 100.21 |
| 2105 | Нормативт зардал | 40,579,500.00 | 40,574,630.00 | 4,870.00 | 99.99 |
| 210502 | Хоол, хүнс | 40,579,500.00 | 40,574,630.00 | 4,870.00 | 99.99 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 57,720,900.00 | 57,362,020.00 | 358,880.00 | 99.38 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 54,720,900.00 | 54,362,020.00 | 358,880.00 | 99.34 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0 | 0 | 0.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,997,600.00 | 21,039,946.00 | 5,957,654.00 | 77.93 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,589,000.00 | 15,169,000.00 | 5,420,000.00 | 73.68 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,793,000.00 | 2,884,630.00 | -91,630.00 | 103.28 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 220,000.00 | 220,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,252,300.00 | 1,623,000.00 | 629,300.00 | 72.06 |
| 210807 | Газрын төлбөр | 1,143,300.00 | 1,143,316.00 | -16.00 | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,544,000.00 | 0 | 1,544,000.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,544,000.00 | 0 | 1,544,000.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,986,500.00 | 7,986,400.00 | 100.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,986,500.00 | 7,986,400.00 | 100.00 | 100.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,116,400.00 | 2,116,400.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,870,100.00 | 5,870,000.00 | 100.00 | 100.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0 | 0 | 0.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 0 | 0.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0 | 0 | 0.00 | - |
| 22-226 | Дотоод эх үүсвэрээр | 0 | 0 | 0.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0 | 0 | 0.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 1,684,515,400.00 | 1,671,497,022.31 | 13,018,377.69 | 99.23 |
| 3 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 41 | 38 | 3 | 92.68 |
| 4 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 0 | 0 | 0.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

***/төгрөгөөр/***

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 13 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 59,284,980.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 59,284,980.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,707,480.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46,577,500.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 59,284,980.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 59,284,980.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 58,684,980.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0 |
| 210101 | Үндсэн цалин | 0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,686,880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,686,880.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,295,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,295,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,057,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,057,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,645,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,645,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 600,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 59,284,980.00 |

## 3. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагааны чиг үүргийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлжээ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь эрхэм зорилгоо “Гамшгаас хамгаалах, сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ” гэж тодорхойлон дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд стандартыг мөрдөж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, нэгдсэн мэдээллийн санг баяжуулах;
- Алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх

## 4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 129,707.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

## 5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар:

Онцгой байдлын байгууллагын оны шилдэг алба хаагчийг шагнаж урамшуулах журмыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид шагнал олгох” журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх талаар анхаарах.

## 6. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,000.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 13,211.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 1,211.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 12,000.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 13,211.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 7. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын тодруулга тайланд шилжүүлэн авсан тусгай зориулалтын материалын дүнг тусгаагүй байна. | 1 | 11,000.0 | 1 | 11,000.0 | | | 1 | 11,000.0 | | | | |
| Дүн | 1 | 11,000.0 | 1 | 11,000.0 | | | 1 | 11,000.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан хаагчдад мөнгөн урамшууллыг давхардуулан илүү олгосон байна. | 1 | 1,211.2 | 1 | 1,211.2 | | | | | | | | |
| "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" албан даалгаврыг хэрэгжүүлж | 1 | 7,000.0 | | | | | 1 | 7,000.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ажиллаагүй, зудын эрсдэлийн үнэлгээ хийх ажлын гэрээ байгуулсан байна. | | | | | | | | | | | | |
| Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй ажил гүйлгээг бүртгэн, гүйцэтгэлийн үр дүнг тооцоогүй байна. | 1 | 5,000.0 | | | | | 1 | 5,000.0 | | | | |
| Дүн | 3 | 13,211.2 | 1 | 1,211.2 | | | 2 | 12,000.0 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 124,707.2 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 5,000.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй, 22 шийдвэрийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | 129,707.2 | | | | | 1 | 129,707.2 | | | | |
| Дүн | 1 | 129,707.2 | | | | | 1 | 129,707.2 | | | | |